ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ ТАНДАЛТ
СУДАЛГААНЫ АЛБА

ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН ТАЙЛАН

2019

Хянасан: Б.Түмэн-Өлзий /Албаны дарга,
мэдээлэл зүйн мэргэжилтэн, АУ-ны докторант/

Тайлан боловсруулсан: А.Жаргалмаа /Албаны эпидемиологич их эмч, НЭМ-ийн ухааны магистрант/

Б.Баянзул /Албаны НЭМ-ийн мэргэжилтэн/

ГССҮТӨВ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ ТАНДАЛТ СУДАЛГААНЫ АЛБА

2020 он

ГАРЧИГ

- Товчилсон үгийн жагсаалт
- Үзүүлэлт тооцох аргачлал

БҮЛЭГ 1

- 2019 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн байдалд хийгдсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 2

- 2019 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын байдалд хийгдсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 3

- Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын мэдээ, тайлангийн үнэлгээ
- Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын бүртгэл, цахим мэдээний сан, сарын мэдээ, жилийн эцсийн тайлантай холбоотой анхаарах зүйлс, нийтлэг гарч буй хүндрэл, алдааны тухай

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
СМТСА	Статистик мэдээлэл тандалт судалгааны алба
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
ЦТЭ	Цэргийн төв эмнэлэг
ТЗНЭ	Төмөр замын нэгдсэн эмнэлэг
ТТАХНЭ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
ХАЯТТ	Хүлээн авах яаралтай тусламжийн тасаг
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БГДЭМТ	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв
БЗДНЭМТ	Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
СХДНЭМТ	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
СБДНЭМТ	Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
ХУДНЭМТ	Хан уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
ЧДНЭМТ	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв
НаДЭМТ	Налайх дүүргийн эрүүл мэндийн төв
БнДЭМТ	Багануур дүүргийн эрүүл мэндийн төв
БхДЭМТ	Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв

ҮЗҮҮЛЭЛТ ТООЦСОН АРГАЧЛАЛ

1. Осол гэмтлийн өвчлөлийн тохиолдлын түвшинг (ТТ) тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шинэ тохиолдлын тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
2. Осол гэмтлийн тархалтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд осол гэмтлийн шалтгаанаар эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлын тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
3. Осол гэмтлийн шалтгаан тус бүрийн өвчлөлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн (ӨОУА-10 дагуу осол гэмтлийн шалтгаан тус бүрээр) осол гэмтлийн шинэ өвчлөлийн тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
4. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тухайн жилийн хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
5. Осол гэмтлийн үхлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн өвчлөлийн тоонд харьцуулан, 1 000 гэмтэл тутамд тооцно.
6. Осол гэмтлийн шалтгаан бүрт нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд тухайн шалтгаанаар бүртгэгдсэн нас баралтыг тухайн жилийн хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.
7. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын болон өвчлөлийн тархалтыг харуулахдаа тухайн аймаг, дүүрэгт бүртгэгдсэн тохиолдлыг тухайн аймаг дүүргийн хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.

БҮЛЭГ 1

- 2019 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн байдалд хийсэн дүн шинжилгээ

МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛИЙН БАЙДАЛ 2019 он

1.1. Ерөнхий хэсэг

2019 онд Монгол улсын хэмжээнд 156723 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 23.7 хувиар хувиар өссөн үзүүлэлттэй байна. 10000 хүн амд ногдох осол гэмтлийн түвшин 26.6 промиллээр өсчээ.

Осол гэмтэлд өртөгсдийн 61.6% нь эрэгтэй, 38.4% нь эмэгтэй байна. Тохиолдлын түвшин эрэгтэйд 606.7, эмэгтэйд 365.3 байгаа нь осол гэмтлийн өвчлөлд эрчүүд эмэгтэйчүүдээс 1.7 дахин их өртөж байгаа үзүүлэлттэй байна.

2019 онд осол гэмтлийн шалтгаант шинэ тохиолдлын тоо 5 хүртэлх насанд хамгийн их байна. Харин 10 000 хүн амд ногдох осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн түвшин 15-19 насанд /535.2/ хамгийн өндөр байна. Осол гэмтлийн шинэ тохиолдол бүх насны бүлэгт өссөн үзүүлэлттэй байна

Насны бүлэг	2017 он		2018 он		2019 он	
	Тохиолдлын тоо	10 000 хүн амд	Тохиолдлын тоо	10 000 хүн амд	Тохиолдлын тоо	10 000 хүн амд
0-4	13203	334.7	18199	461.3	**19738**	504.6
5-9	8970	278.1	12423	385.1	13854	386.6
10-14	8091	367.1	10830	491.3	13008	515.1
15-19	9027	381.9	10806	457.1	12224	535.2
20-24	10073	394.8	12182	477.5	13252	541.0
25-29	13400	426.0	15167	482.2	15357	521.4
30-34	11625	424.3	14272	520.9	15644	530.1
35-39	9226	389.9	10906	460.9	11760	481.5
40-44	7962	371.9	9145	427.1	10214	460.3
45-49	6408	353.2	7702	424.6	8483	442.3
50-54	5847	367.6	6992	439.5	7437	452.9
55-59	4349	362.8	5494	458.3	6089	449.2
60-64	2772	374.9	3463	468.4	3915	446.0
65-69	1613	369.0	1938	443.4	2189	435.1
70+	2755	374.4	3144	427.8	3559	458.4

2019 онд осол гэмтэлд өртөж гэмтсэн нийт хүмүүсийн 45% нь дунд боловсролтой, 24% нь боловсролгүй, 15% дээд боловсролтой байна. Мөн осол гэмтэлд өртсөн 3 хүн тутмын 1 нь 0-15 насны хүүхэд, 2-3 нь ажилгүй хүн байна. Нийт гэмтсэн хүмүүсийн 28.9% нь */ажилчин, албан хаагч, малчин, бусад/* эрхэлсэн ажилтай иргэн байна.

2019 ОНЫ ОСОЛ ГЭМТЛИЙН ШИНЭ ТОХИОЛДЛЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН:

1. Уналт W00-W19 /41.2%/
2. Амьгүй механик хүчинд өртөх W20-W49 /17.0%/
3. Зам тээврийн осол V00-V99 /13.4%/
4. Хүчирхийлэл X85-Y09 /11.3%/
5. Амьтай механик хүчинд өртөх W50-W64 /6.9%/

Осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн байдлыг хүйсээр дараах хүснэгтээс харна уу.

Осол гэмтлийн шалтгаан	**Бодит тоо** /n=156723/		**Тохиолдлын түвшин 10 000 хүн амд**	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Уналт W00-W19	35397	29175	222.4	177.2
Амьгүй механик хүчинд өртөх W20-W49	18377	8262	115.4	50.2
Хүчирхийлэл X85-W09	13282	7696	83.4	46.7
Зам тээврийн осол V00-V99	13210	4470	83.0	27.1
Амьтай механик хүчинд өртөх W50-W64	6666	4200	41.9	25.5
Түлэгдэлт W85-X19	3535	3169	22.2	19.2
Шалтгаан тодорхойгүй осол	2752	1756	17.3	10.7
Хорт бодист өртөх X40-X49	1215	628	7.6	3.8
Амиа хорлох X60-X84	800	322	5.0	2.0
Байгалийн хүчинд өртөх X30-X39	683	177	4.3	1.1
Бусад X50-X59, Y35-Y99	360	169	2.3	1.0
Амьсгал боох аюултай бусад осол W75-W84	153	57	1.0	0.3
Усанд живэх W65-W74	97	22	0.6	0.1
Хортой амьтан ургамалд хатгуулах X20-X29	45	48	0.3	0.3
Нийт	**96572**	**60151**	**606.7**	**365.3**

Түүнчлэн насны бүлгээс хамааран осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан өөр өөр байдаг. Жишээ нь: Бүх насанд уналт 1-р шалтгаан болж байгаа боловч 5 хүртэлх насанд түлэгдэлт, 5-24 болон 40-49 насанд амьгүй механик хүчинд өртөх 2-р шалтгаан болж байгаа бол 25-39 насанд хүчирхийлэл, 50-аас дээш насанд зам тээврийн осол дэд байрт орж байна. Түүнчлэн 5 хүртэлх нас болон 65-аас дээш насанд шалтгаан тодорхойгүй осол гэмтэл 5-рт орж байна.

Насны бүлэг	**Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан**				
	I	**II**	**III**	**IV**	**V**
0-4 нас n=19738	Уналт-9011	Түлэгдэлт-3614	Амьгүй механик хүчинд өртөх-2775	Амьд механик хүчинд өртөх-1816	Тодорхойгүй-1264
5-9 нас n=13854	Уналт-7320	Амьгүй механик хүчинд өртөх-2204	Зам тээврийн осол-1623	Амьд механик хүчинд өртөх-1447	Түлэгдэлт-614
10-14 нас n=13008	Уналт-6674	Амьгүй механик хүчинд өртөх-2052	Зам тээврийн осол-1794	Амьд механик хүчинд өртөх-1395	Хүчирхийлэл-516
15-19 нас n=12224	Уналт-5268	Амьгүй механик хүчинд өртөх-2364	Зам тээврийн осол-1725	Хүчирхийлэл-1237	Амьд механик хүчинд өртөх-1003
20-24 нас n=13252	Уналт-4073	Амьгүй механик хүчинд өртөх-2805	Хүчирхийлэл-2467	Зам тээврийн осол-2122	Амьд механик хүчинд өртөх-821
25-29 нас n=15357	Уналт-4794	Хүчирхийлэл-3143	Амьгүй механик хүчинд өртөх-3122	Зам тээврийн осол-2313	Амьд механик хүчинд өртөх-843
30-34 нас n=15644	Уналт-5075	Хүчирхийлэл-3220	Амьгүй механик хүчинд өртөх-3085	Зам тээврийн осол-2266	Амьд механик хүчинд өртөх-757
35-39 нас n=11760	Уналт-3732	Хүчирхийлэл-2262	Амьгүй механик хүчинд өртөх-2221	Зам тээврийн осол-1915	Амьд механик хүчинд өртөх-603
40-44 нас n=10214	Уналт-3461	Амьгүй механик хүчинд өртөх-1823	Хүчирхийлэл-1728	Зам тээврийн осол-1676	Амьд механик хүчинд өртөх-484
45-49 нас n=8483	Уналт-3200	Амьгүй механик хүчинд өртөх-1448	Зам тээврийн осол-1371	Хүчирхийлэл-1158	Амьд механик хүчинд өртөх-413
50-54 нас n=7437	Уналт-3083	Зам тээврийн осол-1249	Амьгүй механик хүчинд өртөх-1070	Хүчирхийлэл-825	Амьд механик хүчинд өртөх-435
55-59 нас n=6089	Уналт-2893	Зам тээврийн осол-954	Амьгүй механик хүчинд өртөх-798	Хүчирхийлэл-518	Амьд механик хүчинд өртөх-364
60-64 нас n=3915	Уналт-2106	Зам тээврийн осол-530	Амьгүй механик хүчинд өртөх-449	Амьд механик хүчинд өртөх-228	Хүчирхийлэл-207
65-69 нас n=2189	Уналт-1321	Зам тээврийн осол-294	Амьгүй механик хүчинд өртөх-208	Амьд механик хүчинд өртөх-109	Тодорхойгүй осол-86
70+ нас n=3559	Уналт-2561	Зам тээврийн осол-304	Амьгүй механик хүчинд өртөх-215	Амьд механик хүчинд өртөх-148	Тодорхойгүй осол-118

Нийт гэмтэгсдийн **24.4%** нь толгойн гэмтлийн үндсэн онош тавигдсан байгаа нь хамгийн их хувийг эзэлж байна. Дээд мөчдийн гэмтэл нийтдээ **29.5%**-ийг, доод мөчдийн гэмтэл **24.2%**-ийг эзэлж байна.

2019 онд осол гэмтлийн шалтгаанаар эмнэлгийн тусламж авсан хүмүүсийн 28.2% нь зөөлөн эдийн гэмтэлтэй, 20.6% нь ямар нэг эрхтний шархтай байгаа бол 19.9% нь аль нэг ясны хугарлын оношоор тусламж авчээ.

2019 онд осол гэмтлийн шалтгаант өвчлөл 6 сард 9.6% буюу хамгийн их, 2 сард хамгийн бага буюу 6.7% бүртгэгдсэн байна.

Осол гэмтлийн шалтгаанаар эмнэлэгт хандсан байдал хавар, зуны улиралд их байна.

2019 онд бүртгэгдсэн нийт ослын 84% нь буюу 131885 тохиолдол нь нийслэлд 16% нь орон нутагт бүртгэгджээ. Нийслэлийн 10000 хүн тутамд 884 хүн гэмтэж байгаа бол орон нутагт 142 хүн гэмтэж байна.

Орон нутагт осол гэмтлийн шалтгаанаар эмнэлгийн тусламж авсан үйлчлүүлэгч бодит тоогоор болон тухайн аймгийн 10000 хүн тутамд гэмтсэн тохиолдлын түвшингээр Дорноговь аймагт хамгийн өндөр, Баян-Өлгий аймаг бодит тоогоор болон тухайн аймгийн 10000 хүн тутамд гэмтсэн тохиолдлын түвшингээр хамгийн бага үзүүлэлттэй байна.

Түүнчлэн аймаг бүрт осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан харилцан адилгүй байна. Тухайлбал хэд хэдэн аймгийн осол гэмтлийн 3,4,5-р шалтгаанд түлэгдэлт орсон байна.

Аймгийн нэр		Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан				
		I	II	III	IV	V
1	Архангай	ЗТО	Хүчирхийлэл	Уналт	Амьгүй м/х өртөх	Амьтай м/х өртөх
2	Баян-Өлгий	Уналт	ЗТО	Амьгүй м/х өртөх	Хүчирхийлэл	Амьтай м/х өртөх
3	Баянхонгор	ЗТО	Уналт	Хүчирхийлэл	Амьгүй м/х өртөх	Түлэгдэлт
4	Булган	ЗТО	Уналт	Амьгүй м/х өртөх	Хүчирхийлэл	Амьтай м/х өртөх
5	Говь-Алтай	ЗТО	Уналт	Амьгүй м/х өртөх	Амьтай м/х өртөх	Хүчирхийлэл
6	Говьсүмбэр	Уналт	ЗТО	Амьгүй м/х өртөх	Хүчирхийлэл	Амьтай м/х өртөх
7	Дархан-уул	Уналт	Амьгүй м/х өртөх	ЗТО	Хүчирхийлэл	Түлэгдэлт
8	Дорноговь	Уналт	ЗТО	Хүчирхийлэл	Амьгүй м/х өртөх	Түлэгдэлт
9	Дорнод	ЗТО	Уналт	Амьгүй м/х өртөх	Амьтай м/х өртөх	Хүчирхийлэл
10	Дундговь	ЗТО	Уналт	Хүчирхийлэл	Амьгүй м/х өртөх	Амьтай м/х өртөх
11	Завхан	ЗТО	Уналт	Амьгүй м/х өртөх	Амьтай м/х өртөх	Хүчирхийлэл
12	Орхон	Уналт	ЗТО	Амьгүй м/х өртөх	Түлэгдэлт	Хүчирхийлэл
13	Өвөрхангай	Уналт	ЗТО	Амьгүй м/х өртөх	Амьтай м/х өртөх	Хүчирхийлэл
14	Өмнөговь	ЗТО	Амьгүй м/х өртөх	Уналт	Хүчирхийлэл	Амьтай м/х өртөх
15	Сүхбаатар	ЗТО	Уналт	Түлэгдэлт	Амьгүй м/х өртөх	Хүчирхийлэл
16	Сэлэнгэ	ЗТО	Хүчирхийлэл	Амьгүй м/х өртөх	Уналт	Амьтай м/х өртөх
17	Төв	Уналт	ЗТО	Амьгүй м/х өртөх	Хүчирхийлэл	Амьтай м/х өртөх
18	Увс	ЗТО	Амьгүй м/х өртөх	Уналт	Түлэгдэлт	Хүчирхийлэл
19	Ховд	Уналт	ЗТО	Амьгүй м/х өртөх	Түлэгдэлт	Хүчирхийлэл
20	Хөвсгөл	ЗТО	Хүчирхийлэл	Амьгүй м/х өртөх	Уналт	Түлэгдэлт
21	Хэнтий	ЗТО	Уналт	Амьгүй м/х өртөх	Хүчирхийлэл	Түлэгдэлт

1.2. “УНАЛТ”-ЫН ШАЛТГААНТ ОСОЛ ГЭМТЛИЙН ТОХИОЛДОЛ /W00-W19/

2019 онд бүртгэгдсэн нийт 64572 унаж гэмтсэн иргэдийн 54.8% нь эрэгтэй, 45.2% нь эмэгтэй байна. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.2 дахин их унаж гэмтсэн байна.

Унаж гэмтсэн иргэдийг насны бүлэг хүйсээр авч үзэхэд аль ч хүйсэнд тохиолдлын тоо хүүхэд насанд өндөр боловч 10000 хүн тутамд ногдох тохиолдлын түвшин эрэгтэйд 10-14 /338.5/, эмэгтэйд 70+ /367.0/ насанд бусад наснаас өндөр байна.

Бүх насанд нэг түвшин дээр, хальтарч тээглэж бүдэрч ойчих /W01/ төрлийн уналт 1-р шалтгаан болж байна.

Насны бүлэг	Уналтын шалтгаант өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, 2019				
	I	II	III	IV	V
0-4	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 59.18%	Шат гишгүүрээс ойчих 10.59%	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэн ойчих 5.22%	Орноос ойчих 4.91%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 4.44%
5-9	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 60.70%	Шат гишгүүрээс ойчих 9.00%	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэн ойчих 5.98%	Орноос ойчих 5.66%	Тоглоом ба спортын талбай 4.04%
10-14	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 56.47%	Шат гишгүүрээс ойчих 13.65%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.17%	Тоглоом ба спортын талбай 4.67%	Орноос ойчих 4.38%
15-19	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 53.42%	Шат гишгүүрээс ойчих 15.58%	Тоглоом ба спортын талбай 5.01%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.73%	Орноос ойчих 4.08%
20-24	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 53.40%	Шат гишгүүрээс ойчих 13.43%	Орноос ойчих 4.52%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.35%	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэн ойчих 4.22%
25-29	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 55.05%	Шат гишгүүрээс ойчих 11.81%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 6.01%	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэн ойчих 4.71%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.70%
30-34	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 53.97%	Шат гишгүүрээс ойчих 12.33%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 5.30%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.26%	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэн ойчих 4.43%
35-39	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 53.46%	Шат гишгүүрээс ойчих 12.81%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 6.11%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.49%	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэн ойчих 4.21%
40-44	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 52.85%	Шат гишгүүрээс ойчих 12.94%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 6.36%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.40%	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэн ойчих 4.22%
45-49	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 52.75%	Шат гишгүүрээс ойчих 13.47%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.34%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 5.25%	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэн ойчих 3.78%
50-54	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 52.64%	Шат гишгүүрээс ойчих 12.81%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 6.03%	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэн ойчих 5.32%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.93%
55-59	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 53.23%	Шат гишгүүрээс ойчих 13.69%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 5.12%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.42%	Тоглоом ба спортын талбай 4.11%
60-64	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 50.28%	Шат гишгүүрээс ойчих 13.30%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 6.65%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.89%	Хүнтэй мөргөлдөх,түлхэгдэн ойчих 4.42%
65-69	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 52.23%	Шат гишгүүрээс ойчих 13.17%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 6.74%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 5.00%	Тоглоом ба спортын талбай 4.47%
70+	Нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах 54.98%	Шат гишгүүрээс ойчих 12.38%	Нэг түвшин дээр цас мөсөн дээр унах 5.19%	Нэг түвшинээс өөр түвшин рүү ойчих 4.61%	Тоглоом ба спортын талбай 4.14%

Нийт унаж гэмтсэн тохиолдлын 19.8% буюу 12815 нь шагай ба тавхайн гэмтлээр, 18.0% буюу 11625 нь тохой ба шууны гэмтлээр эмнэлгийн тусламж авсан байгаа нь хамгийн их байна.

Гэмтлийн онош	Тохиолдлын тоо	Хувь
Шагай ба тавхайн гэмтэл /S90-S99/	***12815***	19.8
Тохой ба шууны гэмтэл /S50-S59/	***11625***	18.0
Толгойн гэмтэл /S00-S09/	10587	16.4
Өвдөг ба шилбэний гэмтэл /S80-S89/	8624	13.4
Бугуй ба сарвууны гэмтэл /S60-S69/	4622	7.2
Мөр ба бугалгын гэмтэл /S40-S49/	4461	6.9
Хэвлий, зоонуруу, ууц ба аарцгийн гэмтэл /S30-39/	3358	5.2
Цээжний гэмтэл /S20-S29/	3300	5.1
Түнх ба гуя орчмын гэмтэл /S70-S79/	2601	4.0
Их бие , мөч буюу биеийн бүсийн тодорхойгүй хэсгийн гэмтэл /T08-T14/	2066	3.2
Хүзүүний гэмтэл /S10-S19/	281	0.4
Биеийн олон хэсгийг хамарсан гэмтэл /T00-T07/	232	0.4
Нийт	**64572**	100%

Нийт унаж гэмтсэн тохиолдлын 6.0% нь гэмтэх үедээ согтуурууулах ундаа хэрэглэсэн байжээ. Унаж гэмтсэн 3 хүн тутмын 1 нь /22692/ нь гэртээ байхдаа, 1 нь /18434/ гудамж зам талбайд явж байхдаа гэмтжээ.

Нийт унаж гэмтсэн тохиолдлын 88.9% нь /57440/ нийслэлд бүртгэгдсэн байна. 10 000 хүн ам тутам дахь тохиолдлын түвшин нийслэлд орон нутгаас 344.3 промиллээр их бүртгэгдсэн байна.

1.3. “ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ”-ЫН ШАЛТГААНТ ОСОЛ ГЭМТЛИЙН ТОХИОЛДОЛ /V01-V99/

2019 онд зам тээврийн ослын шалтгаанаар 20978 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Зам тээврийн улмаас энэ онд 10 000 хүн ам тутамд 64.8 хүн гэмтжээ. Энэ нь 2018 оноос 0.9 промиллээр өссөн үзүүлэлт юм. /2018 оны жилийн эцсийн хүн амд тооцов./

Зам тээврийн ослоор гэмтэгсдийн 63% нь эрэгтэй, 37% нь эмэгтэй байгаа ба 10000 эрэгтэй тутамд 83.4 эрэгтэй, 10000 эмэгтэй тутамд 46.7 эмэгтэй гэмтсэн байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.7 дахин өртөмхий байгааг илтгэж байна.

Зам тээврийн ослоор гэмтэгсдийн байдлыг насны бүлгээр судлахад тохиолдлын тоо 30 хүртэлх насанд өсөөд 35 наснаас буурсан үзүүлэлт ажиглагдаж байна. Гэвч тухайн насны бүлэг дэх 10000 хүн тутамд ногдох тохиолдлын түвшин 10-65 нас хүртэл тогтмол өндөр байна. Тохиолдлын тоо 30-34 насанд хамгийн их байгаа бол 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшин 20-24 насанд /86.6/ хамгийн өндөр байна.

2019 онд зам тээврийн ослын улмаас гэмтсэн 10 хүн тутмын 3-4 нь суудлын машинтай явж байх үедээ, 2 нь явган явж байх үедээ, 2 нь мотоциклтэй явж байх үедээ осолджээ.

Зам тээврийн ослын улмаас гэмтсэн 10 хүн тутмын 4 нь толгойн гэмтэл авсан байна.

2019 онд зам тээврийн ослын улмаас гэмтсэн нийт хүмүүсийн 11.3% нь осолд өртөх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байжээ. Эдгээр хүмүүсийн 85.2%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна. Өөрөөр хэлбэл зам тээврийн ослоор гэмтэх үедээ эрэгтэйчүүдийн 17.9%, эмэгтэйчүүдийн 4.8% нь согтууруулах ундаа хэрэглэсэн байжээ.

Зам тээврийн ослын улмаас гэмтсэн хүмүүсийн 68.2% нь нийслэлд, 31.8% нь орон нутагт эмнэлгийн тусламж авсан байна.

Орон нутагт бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгаант гэмтлийн тохиолдлын тоо Дорноговь, Архангай аймгуудад өндөр байгаа бол тухайн аймгийн 10000 хүн амд ногдох зам тээврийн ослын шалтгаант өвчлөлийн түвшин Говьсүмбэр, Дорноговь аймгуудад хамгийн өндөр, Баян-Өлгий, Ховд аймгуудад бага байна.

№	Харъяалал	Бодит тоо			10000 хүн амд
		2017 он	2018 он	2019 он	2019 он
1	Архангай	360	506	535	55.3
2	Баян-Өлгий	82	137	104	9.9
3	Баянхонгор	278	338	338	38.3
4	Булган	152	156	222	35.7
5	Говь-Алтай	422	461	357	61.1
6	Говьсүмбэр	171	219	164	92.2
7	Дархан-уул	188	122	206	19.4
8	Дорноговь	516	661	655	94.5
9	Дорнод	288	346	283	34.9
10	Дундговь	320	270	334	71.6
11	Завхан	288	298	266	36.5
12	Орхон	211	241	244	23.0
13	Өвөрхангай	428	391	281	24.0
14	Өмнөговь	321	480	425	63.7
15	Сүхбаатар	373	282	221	35.5
16	Сэлэнгэ	302	320	289	25.9
17	Төв	254	284	503	52.6
18	Увс	214	212	214	25.4
19	Ховд	142	210	167	18.9
20	Хөвсгөл	407	431	473	35.3
21	Хэнтий	391	416	397	51.5
Орон нутгийн дүн		**6108**	**6781**	**6678**	**38.2**
Улаанбаатар хот		**11495**	**13564**	**14300**	**95.9**
Улсын дүн		**17603**	**20345**	**20978**	**64.8**

Хүснэгтээс харахад ихэнх аймагт зам тээврийн ослын тоо буурсан байгаа бол Архангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дундговь, Орхон, Төв, Увс, Хөвсгөл аймгуудад өссөн үзүүлэлтэй байна.

1.4. “ХҮЧИРХИЙЛЭЛ”-ИЙН ШАЛТГААНТ ОСОЛ ГЭМТЛИЙН ТОХИОЛДОЛ /X85-Y09/

2019 онд хүчирхийллийн шалтгаант өвчлөл 17680 бүртгэгдсэн нь нийт осол гэмтлийн 11.3 хувийг эзэлж байгаа ба 10000 хүн ам тутамд 54.5 хүн хүчирхийллийн улмаас гэмтэж эмнэлэгт хандсан үзүүлэлттэй байна. Тэдний 13210 нь эрэгтэйчүүд байгаа нь эмэгтэйчүүдээс 3 дахин их байна.

Хүчирхийллийн шалтгаант өвчлөлийн тохиолдлын тоо болон 10000 хүн ам тутам дахь тохиолдлын түвшин эрэгтэйд 25-29 насанд, эмэгтэйд 30-34 насанд бусад насны бүлгүүдээс өндөр байна.

2019 онд хүчирхийллийн шалтгаанаар гэмтсэн нийт 17680 иргэдийг хүчирхийллийн хэлбэрээр нь үзэхэд 98% /17320/ нь бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна. Хүчирхийлэгч, хохирогч хоорондын холбоогоор нь судлахад 39.3% нь үл таних хүнд, 31.5% нь танил найз нөхөддөө нь зодуулсан байна.

Хүчирхийлэлд өртсөн хохирогчдын 75.2% буюу 13298 нь биеийн хүчээр халдах халдлагад өртсөн ба 11.9% буюу 2103 нь иртэй зүйлээр халдах халдлагад өртсөн байна.

Хүчирхийллийн шалтгаант осол гэмтэл нийслэлд 83%, орон нутагт 17 % нь бүртгэгдсэн байна. 10000 хүн амд ногдох тохиолдлын түвшин нийслэлд орон нутгаас 5.7 дахин өндөр байна.

Орон нутгийн хувьд тухайн аймгийн 10000 хүн амд ногдох хүчирхийллийн шалтгаант өвчлөлийн тохиолдлын түвшин Дорноговь аймагт /88.6/ хамгийн өндөр байна.

БҮЛЭГ 2

- 2019 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын байдалд хийсэн дүн шинжилгээ

МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН БАЙДАЛ 2019

2.1. Ерөнхий хэсэг

2019 онд гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралтын 2827 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 3.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 10000 хүн амд ногдох нас баралтын түвшин 0.5 промиллээр буурсан байна.

/2018 оны жилийн эцсийн хүн амд тооцов/

2019 онд бүртгэгдсэн осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 79.6% нь эрэгтэйчүүд байгаа ба 10 000 хүн амд ногдох тохиолдлын түвшин эрэгтэйчүүдэд 15.1 байгаа нь эмэгтэйчүүдээс 4 дахин их байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын тоо эрэгтэйчүүдэд 40-44 насанд, эмэгтэйчүүдэд 4 хүртэлх нас болон 40-49 насанд хамгийн их байна.

Тухайн насны бүлэг дэх 10000 хүн амд ногдох осол гэмтлийн шалтгаант нас баралтын түвшин эрэгтэйд 50-54 насанд, эмэгтэйд 45-49 насанд хамгийн өндөр байна.

Гэмтэл хордлого гадны шалтгааны улмаас нас барсан 10 хүн тутмын 6 нь дунд боловсролтой иргэд байгаа ба 10 хүн тутмын 4 нь ажилгүй иргэд байна.

2019 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын 77% нь санамсаргүй үйлдэгдсэн бол 23% нь өөрийнхөө болон бусдын амь насанд санаатайгаар халдсан тохиолдлууд байлаа.

Гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан:

1. Хорт бодист өртөх – 26.5%
2. Зам тээврийн осол – 19.7%
3. Амиа хорлох – 15.7%
4. Байгалийн хүчинд өртөх – 7.6%
5. Бусдад хорлогдох /хүчирхийлэл/ - 7.4%

Осол гэмтлийн нас баралтын тэргүүлэх шалтгаан насны бүлэг бүрт харилцан адилгүй байна.

Насны бүлэг	Нас баралтын тэргүүлэх шалтгаан-2019 он				
	I	II	III	IV	V
0-4нас /n=154/	Амьсгал боогдох-58	Зам тээврийн осол-27	Усанд живэх-25	Түлэгдэлт-15	Хордох -11
5-9нас /n=34/	Зам тээврийн осол-15	Амьсгал боогдох-5	Түлэгдэлт-4	Усанд живэх-4	Уналт-1
10-14нас /n=42/	Зам тээврийн осол-17	Амиа хорлох-8	Хордох -5	Уналт-3	Амьгүй механик хүчинд өртөх-2
15-19нас /n=73/	Амиа хорлох-28	Зам тээврийн осол-22	Уналт-12	Усанд живэх-2	Хүчирхийлэл-2
20-24нас /n=143/	Амиа хорлох-56	Зам тээврийн осол-31	Уналт-14	Усанд живэх-10	Хордох -10
25-29нас /n=200/	Амиа хорлох-63	Зам тээврийн осол-52	Хордох -19	Уналт-16	Хүчирхийлэл-13
30-34нас /n=270/	Амиа хорлох-69	Хордох -66	Зам тээврийн осол-61	Хүчирхийлэл-26	Уналт-12
35-39 нас /n=323/	Хордох-101	Зам тээврийн осол-70	Амиа хорлох-53	Хүчирхийлэл-33	Уналт-13
40-44нас /n=394/	Хордох-141	Зам тээврийн осол-63	Амиа хорлох-50	Хүчирхийлэл-37	Байгалийн хүчинд өртөх-36
45-49нас /n=366/	Хордох-129	Зам тээврийн осол-56	Байгалийн хүчинд өртөх-45	Амиа хорлох-44	Хүчирхийлэл-31
50-54нас /n=320/	Хордох-114	Зам тээврийн осол-55	Байгалийн хүчинд өртөх-37	Амиа хорлох-36	Хүчирхийлэл-22
55-59нас /n=243/	Хордох-74	Зам тээврийн осол-46	Байгалийн хүчинд өртөх-27	Хүчирхийлэл-21	Уналт-20
60-64нас /n=139/	Хордох-55	Зам тээврийн осол-17	Амиа хорлох-13	Уналт-11	Байгалийн хүчинд өртөх-10
65-69нас /n=55/	Хордох-13	Зам тээврийн осол-13	Амиа хорлох-6	Уналт-6	Тодорхойгүй осол-5
70+нас /n=71/	Уналт-18	Зам тээврийн осол-13	Тодорхойгүй осол-10	Хордох-6	Байгалийн хүчинд өртөх-6

2019 онд бүртгэгдсэн нийт осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 56.8% нь нийслэлд, 43.2% нь орон нутагт бүртгэгдсэн ба 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин нийслэлд 10.8, орон нутагт 7.0 байна.

2019 онд орон нутагт осол гэмтлийн шалтгаант нас баралтын 1220 тохиолдол бүртгэгдсэн ба тохиолдлын тоогоор Хөвсгөл аймаг хамгийн өндөр байна. Харин тухайн аймгийн 10000 хүн амд ногдох нас баралтын түвшин Дорноговь аймагт /14.0/ хамгийн өндөр, Баян-Өлгий аймагт /4.1/ хамгийн бага үзүүлэлттэй байна.

Аймаг бүрийн осол гэмтлийн нас баралтын тэргүүлэх шалтгааныг хүснэгтээс харна уу.

Харъяалал	Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
Архангай	*Зам тээврийн осол-27*	*Амиа хорлох-17*	*Хордох-12*	*Усанд живэх-9*	*Амьсгал боогдох-7*
Баян-Өлгий	*Зам тээврийн осол-12*	*Амиа хорлох-10*	*Усанд живэх-9*	*Уналт-7*	*Амьсгал боогдох-2*
Баянхонгор	*Зам тээврийн осол-35*	*Амиа хорлох-13*	*Байгалийн хүчинд өртөх-8*	*Усанд живэх-5*	*Уналт-4*
Булган	*Зам тээврийн осол-14*	*Амиа хорлох-8*	*Хордох-4*	*Байгалийн хүчинд өртөх-3*	*Амьсгал боогдох-3*
Говь-Алтай	*Зам тээврийн осол-12*	*Амиа хорлох-9*	*Амьсгал боогдох-4*	*Уналт-2*	*Байгалийн хүчинд өртөх-2*
Говьсүмбэр	*Зам тээврийн осол-3*	*Хордох-2*	*Байгалийн хүчинд өртөх-1*	*Амиа хорлох-1*	*Хүчирхийлэл-1*
Дархан-Уул	*Хордох-20*	*Зам тээврийн осол-10*	*Амиа хорлох-7*	*Түлэгдэлт-6*	*Хүчирхийлэл-5*
Дорнод	*Зам тээврийн осол-16*	*Амиа хорлох-15*	*Хордох-5*	*Уналт-5*	*Байгалийн хүчинд өртөх-3*
Дорноговь	*Зам тээврийн осол-35*	*Амиа хорлох-20*	*Хордох-18*	*Түлэгдэлт-6*	*Байгалийн хүчинд өртөх-5*
Дундговь	*Зам тээврийн осол-14*	*Амиа хорлох-8*	*Хордох-6*	*Байгалийн хүчинд өртөх-3*	*Амьсгал боогдох-2*
Завхан	*Амиа хорлох-14*	*Зам тээврийн осол-13*	*Амьгүй механик хүчинд өртөх-5*	*Хордох-4*	*Усанд живэх-3*
Орхон	*Хордох-40*	*Амиа хорлох-15*	*Зам тээврийн осол-12*	*Уналт-7*	*Амьсгал боогдох-6*
Өвөрхангай	*Зам тээврийн осол-17*	*Амиа хорлох-15*	*Хордох-11*	*Байгалийн хүчинд өртөх-8*	*Усанд живэх-5*
Өмнөговь	*Зам тээврийн осол-23*	*Амиа хорлох-14*	*Байгалийн хүчинд өртөх-9*	*Хордох-7*	*Хүчирхийлэл-3*
Сүхбаатар	*Зам тээврийн осол-16*	*Байгалийн хүчинд өртөх-7*	*Амиа хорлох-5*	*Хордох-4*	*Хүчирхийлэл-2*
Сэлэнгэ	*Амиа хорлох-12*	*Зам тээврийн осол-12*	*Хордох-7*	*Амьсгал боогдох-7*	*Усанд живэх-6*
Төв	*Зам тээврийн осол-27*	*Хордох-13*	*Байгалийн хүчинд өртөх-12*	*Амьсгал боогдох-8*	*Хүчирхийлэл-3*
Увс	*Амиа хорлох-15*	*Зам тээврийн осол-13*	*Усанд живэх-9*	*Байгалийн хүчинд өртөх-5*	*Амьсгал боогдох-5*
Ховд	*Зам тээврийн осол-16*	*Амиа хорлох-6*	*Усанд живэх-5*	*Амьсгал боогдох-4*	*Уналт-2*
Хэнтий	*Зам тээврийн осол-15*	*Амиа хорлох-7*	*Хордох-7*	*Байгалийн хүчинд өртөх-6*	*Амьсгал боогдох-4*
Хөвсгөл	*Амиа хорлох-28*	*Зам тээврийн осол-28*	*Хордох-18*	*Усанд живэх-11*	*Амьсгал боогдох-9*
Улаанбаатар	*Хордох-559*	*Амиа хорлох-203*	*Зам тээврийн осол-188*	*Хүчирхийлэл-162*	*Уналт-135*

2.2. “САНАМСАРГҮЙ ХОРДОХ, ХОРТ БОДИСТ ӨРТӨХ” ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /X40-X49/

Өвчний олон улсын ангиллын 19-р бүлэгт багтах Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгааны улмаас нас барж буй тохиолдол нь Монгол улсын гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралтын 1-р шалтгаан болж байна.

2019 оны байдлаар 10000 хүн амд ногдох нас баралтын түвшин 2.3 байгаа нь өмнөх оноос 0.3 промиллээр буурсан үзүүлэлттэй байна.

Нийт нас барсан тохиолдлын 79% нь эрэгтэйчүүд, 21% нь эмэгтэйчүүд байна. 10000 эрэгтэй тутамд 3.7 эрэгтэй, 10000 эмэгтэй тутамд 0.9 эмэгтэй санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаанаар нас барж байна.

Санамсаргүй хордох, хорт бодист өртсөн тохиолдол 45-49 хамгийн өндөр байгаа бол 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 50-54 насанд их байна. 2019 онд 5-9 хүртэлх насанд санамсаргүй хордох, хорт бодист өртсөн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Санамсаргүй хордсон, хорт бодисд өртөж нас барсан тохиолдлын 66% нь дунд, 14% нь дээд, 12% нь мэргэжил техникийн, 5% нь бага боловсролтой байсан бол дээрх хүмүүсийн 46.6% -ийг ажилгүй, 25.1%-ийг ажилчин, албан хаагч, 10 орчим хувийг тэтгэвэрийн насны хүмүүс эзэлж байна.

Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаанаар нас барсан тохиолдлыг хордсон бодисын төрлөөр ангилвал **спиртэнд санамсаргүй хордсон тохиолдол дангаараа 89.3%-ийг эзэлж байна.**

ӨОУА	Спиртэнд санамсаргүй хордох	Нас барсан хүний тоо	Эзлэх хувь
X45	**Спиртэнд санамсаргүй хордох**	**668**	**89.3**
X47	Бусад хий, ууранд санамсаргүй хордох, өртөх	50	6.7
X49	Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох, өртөх	18	2.41
X44	Бусад ба тодорхойгүй эм, эмийн бэлдмэл, биологийн бодист санамсаргүй хордох, өртөх	6	0.8
X46	Органик уусгагч, галоген агуулсан нүүрс устөрөгч, тэдгээрийн ууraар санамсаргүй хордох, өртөх	4	0.5
X40	Өөр бүлэгт ангилаагүй таталтын эсрэг, тайвшруулах, паркинсоны өвчний эсрэг, сэтгэц нөлөөт эмэнд санамсаргүй хордох, өртөх	1	0.1
X48	Хортон шавьж устгах хоронд санамсаргүй хордох өртөх	1	0.1

Монгол улсад 10000 хүн тутам 2-3 хүн спиртэнд санамсаргүй хордож нас барж байна. /Ихэнх нь олон хоног үргэлжлүүлэн архи уусан тохиолдлууд байлаа/

Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, хордсон бодисын төрлөөр, 10000 хүн амд

ӨОУА	Хордсон бодисын нэр төрөл	2018 он	2019 он
X45	Спиртэнд санамсаргүй хордох, өртөх	2.28	2.1
X47	Бусад хий, ууранд санамсаргүй хордох, өртөх	0.24	0.2
X49	Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох, өртөх	0.06	0.1
X44	Бусад ба тодорхойгүй эм, эмийн бэлдмэл, биологийн бодист санамсаргүй хордох, өртөх	0.01	0.0
X46	Органик уусгагч, галоген агуулсан нүүрс устөрөгч, тэдгээрийн ууraар санамсаргүй хордох, өртөх	0.01	0.0
X40	Опиоид бус өвчин намдаах, халуун бууруулах ба хэрлэгийн эсрэг эмэнд санамсаргүй хордох, өртөх	0.00	0.0
X48	Хортон шавьж устгах хоронд санамсаргүй хордох өртөх	0.00	0.0

2019 онд санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын 66% нь нийслэлд 34% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Спиртэнд хордож нас барсан тохиолдлын 89.27% нь нийслэлд бүртгэгдсэн байна.

Санамсаргүй хордож, хорт бодисд өртсөн тохиолдол 11 сард хамгийн бүртгэгдсэн байна.

2.3. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /V01-V99/

Зам тээврийн ослын шалтгаант нас баралт нь нийт гадны шалтгаант нас баралтын 19.7%-ийг эзэлж 2-р байранд орж байна. Өөрөөр хэлбэл Монгол улсад 2019 онд гадны шалтгаанаар нас барсан 5 хүн тутмын 1 нь зам тээврийн ослын улмаас амь эрсдэжээ. Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын бодит тоо өмнөх онтой харьцуулахад бага зэрэг өссөн боловч 10000 хүн амд ногдох түвшин хэвээр байна. /2018 оны жилийн эцсийн хүн амд тооцов/

2019 онд зам тээврийн ослоор нас барсан хүмүүсийн 77.1% нь эрэгтэйчүүд байна. Өөрөөр хэлбэл 10 000 эрэгтэй тутамд 2.7 эрэгтэй, 10 000 эмэгтэй тутамд 0.8 эмэгтэй зам тээврийн ослын улмаас амиа алдсан байна.

2019 онд зам тээврийн ослын шалтгаант нас баралтын тоо 35-39 /70/ насанд өндөр байгаа бол нас баралтын түвшин 55-59 /3.4/ насанд өндөр байна.

Зам тээврийн осолд өртөж нас барсан тохиолдлын 34.1% нь суудлын машин дотор явж байсан бол 27.2% явган явж байх үедээ, 27.1% мотоциклын осолд орж нас баржээ.

2019 онд зам тээврийн ослын шалтгаанаар нас барсан нийт 558 тохиолдлын 34% нь буюу 191 хүн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртсөн байна. Дээрх согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдлын 86 нь жолооч байжээ.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 66.3% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин 10000 хүн амд нийслэлд 1.3 байгаа бол орон нутагт 2.1 промилл байна.

Монгол улсын хэмжээнд 2019 онд зам тээврийн ослын улмаас гэмтсэн 1000 хүн тутамд 27 тохиолдол нас баралтаар төгссөн байна. Энэ үзүүлэлт нийслэлд 13.1, орон нутагт 55.4 байгаа нь орон нутгийн зам дээр болсон осол амь насанд 4 дахин эрсдэлтэйг харуулж байна.

Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын тоо Баянхонгор /35/, Дорноговь /35/ өндөр байгаа бол нас баралтын түвшин Дорноговь /5.1/ аймагт өндөр байна.

2.4. “АМИА ХОРЛОХ” ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /X60-X84/

2019 онд амиа хорлох оролдлого хийсэн 1122 тохиолдлоос 445 тохиолдол нь нас баралтаар төгссөн байна. Тэдний 88% буюу 392 нь эрэгтэйчүүд, 12% буюу 53 нь эмэгтэйчүүд байжээ.

Нас баралтын тохиолдлын тоо эрэгтэйд 30-34 насанд /64/, эмэгтэйд 20-24 насанд /9/ бусад насны бүлгүүдээс өндөр байгаа бол 10000 хүн ам тутамд нас баралтын түвшин эрэгтэйд 50-54 насанд /4.6/, эмэгтэйд 20-24, 40-49 насанд /0.7/ бусад насны бүлгүүдээс өндөр байна. Мөн 2019 онд эмэгтэйд 5-9, 55-59 насанд амиа хорлох шалтгаант нас баралт бүртгэгдээгүй байна.

Амиа хорлож нас барсан нийт 445 тохиолдлын 42% буюу 188 нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ амиа егүүтгэсэн байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ амиа хорлож нас барсан 188 тохиолдлын 94.7% буюу 178 нь эрэгтэйчүүд байна.

Амиа хорлож нас барсан нийт 445 тохиолдлын 90.3% буюу 402 нь дүүжлэх, боймлох аргыг хэрэглэж өөрийгөө хөнөөсөн байна.

2019 онд бүртгэгдсэн амиа хорлож нас барсан 445 тохиолдлын 69.9% тодорхойгүй сэдлээр, 15.1% нь сэтгэл санааны дарамтнаас үүдэлтэй амиа хорлосон байна.

Амиа хорлож нас барсан нийт тохиолдлын 40% нь гэртээ, 6% нь гудамж зам талбайд, 5% нь ХАА, Фермд, 1% байршил тодорхойгүй, үлдсэн 48% нь бусад газар амиа хорлосон байна.

2019 онд бүртгэгдсэн амиа хорлож нас барсан 445 тохиолдлын 45.6% /203/ нь нийслэлд, 54.4% /242/ нь орон нутагт бүртгэгдсэн байна. Нийслэлд 10000 хүн ам тутамд нас баралтын түвшин 1.36 промилл, Орон нутагт 1.39 промилл байна.

Амиа хорлож нас барсан тохиолдлын тоо Хөвсгөл /28/ аймагт хамгийн өндөр байгаа бол тохиолдлын түвшин Дорноговь /2.9/ аймагт бусад аймгуудаас өндөр байна.

БҮЛЭГ 3

- Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын мэдээ, тайлангийн үнэлгээ
- Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын бүртгэл, цахим мэдээний сан, сарын мэдээ, жилийн эцсийн тайлантай холбоотой анхаарах зүйлс, нийтлэг гарч буй хүндрэл, алдааны тухай

3.1. Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны Осол гэмтлийн тандалтын тайлан хамгаалсан үнэлгээ

Үнэлгээний тайлбар:

2019 оны “Осол гэмтэл, гадны шалтгааны үр дагавар”-ын тайланг хүлээн авахдаа харилцагч эрүүл мэндийн байгууллагуудыг 6 үзүүлэлтээр үнэлсэн. Үүнд:

1. Цахим тайлангийн үнэлгээг Hinfo V3.0 программаас бодуулсан ЭМТ-313.1, ЭМТ-313.2, ЭМТ-313.4 тайлангуудыг сарын мэдээтэй тулган үнэлсэн.
2. Нас баралтын мэдээ болон бааз гэсэн үнэлгээг сар бүр мэдээллэж байсан гадны шалтгаант нас баралт нь Hinfo V3.0 программын АМ-7 -оос экспортолсон бааз болон ЭМХТөвийн мэдээтэй таарч буй байдлаар үнэлсэн.
3. Стационарын баазад өгсөн үнэлгээг өөрийн эмнэлэгт осол гэмтлийн шалтгаанаар хэвтэн эмчлүүлсэн өвчтөний мэдээллийг цахимаар илгээсэн байдлаар үнэлсэн.
4. Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдлыг сар бүрийн 5-ны дотор мэдээлсэн бүх сарыг 12-т хуваан 100-аар үржүүлэн үнэлсэн.
5. Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироог үнэлэхдээ ЭМХТөв, НЭМГазарт мэдээллэж байсан осол гэмтлийн мэдээ нь тандалтын мэдээтэй таарч буй эсэхээр үнэлсэн.
6. Мэдээний сангийн алдааг “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас” маягтын асуумж бүрээр үнэлсэн.

Төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн үнэлгээний хуудас

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Үнэлгээний төрөл						Дүн /%/
		ЭМТ 313.1 ЭМТ 313.2 ЭМТ 502 маягтуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй таарсан	Тайлангаа хугацаанда а өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа	
		30 оноо	10 оноо	10 оноо	12 оноо	12 оноо	26 оноо	
1	УНТЭ	30	10	10	12	10	23	**95%**
2	УХТЭ	30	10	10	10	12	26	**98%**
3	УГТЭ	30	10	10	12	9	26	**97%**
4	ЭХЭМҮТ	30	10	10	12	12	22	**96%**
5	ГССҮТ	30	10	10	12	12	26	**100%**
6	СЭМҮТ	30	10	10	12	9	26	**97%**
7	ШШҮТ	30	5	10	12	12	26	**95%**

Орон нутгийн ЭМГазруудын үнэлгээний хуудас

№	Аймгийн нэр	Үнэлгээний төрөл						Ерөнхий үнэлгээ /%/
		ЭМТ 313.1 ЭМТ 313.2 ЭМТ 502 маягтуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй таарсан	Тайлангаа хугацаандаа өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа	
		30 оноо	10 оноо	10 оноо	12 оноо	12 оноо	26 оноо	100
1	Архангай	30	10	10	12	10	25	**97%**
2	Баян-Өлгий	30	10	9	8	12	25	**94%**
3	Баянхонгор	30	10	10	11	12	25	**98%**
4	Булган	30	10	10	8	12	25	**95%**
5	Говь-Алтай	30	10	9	12	12	24	**97%**
6	Говьсүмбэр	30	10	9	11	12	25	**97%**
7	Дархан-Уул	30	10	9	10	10	25	**96%**
8	Дорноговь	30	10	10	12	12	26	**100%**
9	Дорнод	30	10	10	11	12	25	**98%**
10	Дундговь	30	10	10	12	12	25	**99%**
11	Завхан	30	10	9	11	12	24	**97%**
12	Орхон	30	10	10	11	12	25	**98%**
13	Өвөрхангай	30	10	10	8	12	26	**96%**
14	Өмнөговь	30	10	10	10	12	25	**97%**
15	Сүхбаатар	30	10	9	12	12	24	**97%**
16	Сэлэнгэ	30	10	9	12	12	25	**98%**
17	Төв	30	10	10	11	12	25	**98%**
18	Увс	30	10	10	12	12	25	**99%**
19	Ховд	30	10	10	4	10	26	**90%**
20	Хөвсгөл	30	5	10	10	12	25	**92%**
21	Хэнтий	30	10	9	12	11	23	**95%**

НЭМГазрын харъяа эмнэлгүүдийн үнэлгээний хуудас

№	Аймгийн нэр	Үнэлгээний төрөл						Дүн /%/
		ЭМТ 313.1 ЭМТ 313.2 ЭМТ 502 маягтуудаар бодогдсон тайлан сарын мэдээний нэгтгэлтэй таарсан	Тайлангаа хугацаандаа өгсөн	Стационарийн бааз, логикийн зөрүүгүй	Сарын мэдээг хугацаандаа өгсөн байдал	Сарын мэдээ, бааз, ЭМХТөвийн мэдээ 3-н тохироо	Мэдээний сангийн алдаа	
		30 оноо	10 оноо	10 оноо	12 оноо	12 оноо	26 оноо	
1	Хүүхдийн төв сувилал	30	10	10	6	ЭМХТөвд мэдээ өгөөгүй	26	**85%**
2	Наркологи	Өвчлөл, нас баралт бүртгэгдээгүй			12	12	26	**100%**
3	Энэрэл	30	10	10	11	12	25	**98%**
4	ЦТЭ	30	9	10	9	12	20	**90%**
5	ТЗНЭ	30	10	10	7	12	26	**97%**
6	ТТАХНЭ	30	10	10	10	12	25	**97%**
7	БГДНЭ, ЭМТ	30	5	10	6	6	25	**82%**
8	БЗДНЭ	30	10	10	8	12	26	**96%**
9	БЗДЭМТ	30	10	10	8	12	26	**95%**
10	СХДЭМТ	30	10	9	8	12	26	**94%**
11	СБДНЭ, ЭМТ	30	8	10	5	12	26	**91%**
12	СБДЭМТ	Тайлан хамгаалалтад ирээгүй						
13	ХУДНЭ, ЭМТ	30	10	10	11	12	26	**99%**
14	ЧДНЭ, ЭМТ	30	10	10	12	12	26	**100%**
15	Налайх	30	10	7	11	12	20	**90%**
16	Багануур	30	10	10	11	11	20	**92%**
17	Багахангай	30	8	10	9	12	21	**90%**
18	Жаргалант	30	5	10	3	0	25	**73%**
19	Гачуурт	Өвчлөл, нас баралтын тохиолдол бүртгэгдээгүй						**93%**
20	Хонхор	30	10	10	11	12	22	**95%**
21	Туул	30	5	10	10	11	24	**90%**
22	Мөнгөнгүүр	30	7	8	6	12	26	**91%**
23	Интермед	30	10	10	10	12	26	**98%**

Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын мэдээний санд сар бүр гарч буй нийтлэг алдааны тухай

ГССҮТөвийн СТСАлбаны мэргэжилтнүүд эмнэлгүүдийн осол гэмтлийн өвчлөл, нас баралтын сарын мэдээг цахимаар хүлээн авч Hinfo V3.0 программ дахь бүртгэлтэй тулган, бүртгэлийн болон логик алдаа байгаа тохиолдолд тухай бүрт нь хариу илгээдэг тул очсон и-мэйл-н дагуу мэдээний сангийн алдаагаа сар бүрдээ хянаж хэвшинэ үү!

/Тайлангийн үеэр эмнэлэг бүрт биечлэн дэлгэрэнгүй тайлбарлаж зааж өгсөн ба дараах зүйлсийг анхан шатанд үзлэг хийн маягт хөтөлж буй эмч нартаа анхааруулна уу/

1. Регистрийн дугаар буруу орсон тохиолдолд нас, хүйс буруу бүртгэгдэх тохиолдол байна. Жишээ нь: 100-аас дээш настай хүмүүсийн ихэнх нь регистрийн дугаар буруу оруулсантай холбоотойгоор нас нь 100-р нэмэгдсэн буюу хүүхдүүд байх нь элбэг байдаг. Тиймээс 100-аас дээш настай хүмүүсийн бүртгэлээ үнэн эсэхийг нягталж хэвшинэ үү
2. 15 хүртэлх насны хүүхдүүд дунд, дээд боловсролтой болон аль нэг газар ажил эрхэлдэг гэсэн сонголт хийгдсэн байгаа эсэхийг шалгаж хэвших. Учир нь 5 настай хүүхдэд дээд боловсролтой, мөн 8 настай хүүхдэд ажил эрхэлдэг гэх мэт логикийн хувьд алдаатай бүртгэлүүд элбэг тохиолддог. Энэ нь хувь хүний мэдээллийн хэсгийг сайн шалгаагүйтэй холбоотой. Түүнчлэн хүүхэд байх үед нь бүртгэсэн мэдээллээ шинэчилдэггүйтэй холбоотойгоор насанд хүрсэн хүмүүсийн албан тушаал 0-15 насны хүүхэд гэж бүртгэгдэж байна.
3. Согтууруулах ундаа хэрэглэсэн гэж мэдээлсэн тохиолдлууд дунд насанд хүрээгүй хүүхэд байгаа тохиолдолд үнэн эсэхийг заавал нягталсны дараа бүртгэх, мэдээлэх
4. Мансууруулах бодис хэрэглэсэн гэж сонгогдсон тохиолдолд заавал эргэн шалгах, лавлах
5. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын тоо нь тухайн гэмтсэн хүний ямар тээврийн хэрэгслээр явж байсныг зааж байгаа бөгөөд энэ нь арагш задарсан асуултын 1-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь:
   V тэмдэглэгээний ард 1 гэсэн болон эхний асуултад унадаг дугуйг сонгоно гэсэн үг юм. Явган зорчигч бол V үсэгний ард 0 байна гэх мэт.
6. Зам тээврийн ослын шалтгааны гэмтлийн үед V үсэгний арын 2-р тоо нь тухайн гэмтсэн хүн ямар тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөнийг зааж байгаа ба энэ нь арагш задарсан асуултын 3-р асуулттай таарч байх ёстой. Жишээ нь:
   Суудлын машинтай явж байсан хүн шон мөргөөд түүнээсээ болж гэмтсэн бол 3 дахь асуултанд хөдөлгөөнгүй зүйл мөргөсөн гэдгийг сонгох ба V47-р кодолно.
7. Морь болон тэмээнээс унаж гэмтсэн тохиолдлыг ердийн хөсөгнөөс унасан буюу V80-р кодлох ба 2-р эгнээний асуултанд хариулахдаа жолооч, зорчигч гэх мэт сонголт огт хийхгүй. Зөвхөн уралдааны морь унаач эсвэл энгийн морь унаач гэсэн сонголтыг хийнэ.
8. Хүчирхийлэл буюу өвчний олон улсын ангиллаар Дайралт, халдлага X85-Y09-өөр кодлогддог шалтгаанд биеийн болон бэлгийн бүх төрлийн санаатайгаар нэгнээ гэмтээсэн тохиолдлууд орохыг анхаарна уу. Өөрөөр хэлбэл биеэрээ болон мод, чулуу, шил, хутга гэх мэт зэвсэг ашиглан зодолдсон тохиолдлууд

орно. Зарим тохиолдолд бусдад зодуулсан хүмүүсийн гэмтлийн шалтгааныг W50-аар буруу кодолсон байна. Өвчний олон улсын ангиллаар W50 нь бусад хүнд цохиулах, түлхүүлэх, өшиглүүлэх, мушгиулах, хазуулах, маажуулах тохиолдлууд орох ба энэ нь зөвхөн санамсаргүй гэмтээсэн тохиолдолд л сонгогдох код гэдгийг анхаарна уу. Жишээ нь:
Тоглож байгаад санаандгүй нэгнээ түлхэж унагаад гэмтээсэн, сагс тоглож байгаад санаандгүй маажуулсан, гараа эргүүлж байсан хүнд санаандгүй цохигдох зэрэг нь W50 ангилалд орно. Харин санаатайгаар цохисон, маажсан, өшиглөсөн бол хүчирхийлэл гэсэн ангилалд оруулна. Мөн яг юу ашиглан зодсоныг нь тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлт тайлбар бичнэ үү!

9. Түүнчлэн хүчирхийллийг кодлохдоо хэрэглэсэн арга зүйлээс нь хамаарч ялгаатай кодолдог болохыг анхаарна уу. Жишээ нь:
Санаатайгаар боосон бол X91-р, хутгалсан бол X99-р, мод чулуугаар цохисон бол У00-р, гар хөлөөрөө цохиж зодсон бол У04-р кодлоно.
10. Түлэнхийн шалгаанаар /W85-X19/ тусламж асан хүмүүст T20-T32-н хооронд онош тавих ёстой. Бүртгэгдсэн түлэнхийн тохиолдлууд дунд S-тэй оношууд байгааг анхаарна уу. Түүнчлэн яг юунд хэрхэн түлэгдсэн тухай “тусгай тэмдэглэл” багананд дэлгэрүүлэн бичнэ үү! Жишээ нь: халуун тогоотой зүйлд түлэгдсэн тохиолдлыг заавал тодруулан бичнэ үү
11. “Тусгай тэмдэглэл” хэсэгт нэмэлт тайлбар шаардлагатай тохиолдлуудыг тэмдэглэх ба тухайн мөчид юу болсоныг тусгай тэмдэглэл хэсэгт нэмэлтээр бичнэ. Ингэснээр кодолж чадахгүй байгаа болон эргэлзээтэй тохиолдлуудаа тухай бүрт нь шийдвэрлэх ач холбогдолтой.

НИЙТИЙГ ХАМАРСАН ОСОЛ ГЭМТЭЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН АЛБАНД ЯАРАЛТАЙ МЭДЭЭЛЖ БАЙХЫГ АНХААРУУЛЖ БАЙНА.

Жишээ нь: гэр бүлээрээ болон олноороо явж байгаад зам тээврийн осолд орох, ажлын байр, гэр, байшин шатаж олон хүн түлэгдэх, байгалийн гамшиг тохиолдох, барилга байшин үйлдвэр уурхай нурах гэх мэтээс болж 4 болон түүнээс олон хүн 1 дор гэмтсэн, нас барсан тохиолдлуудыг сарын мэдээний хугацааг хүлээлгүйгээр тухай бүрт gemteltandalt@gmail.com хаягаар болон 88765005, 80081049 дугаарт мэдээлнэ үү!

Та бүхний мэдээлж буй “Осол гэмтлийн тохиолдол” бүрийн үнэн, зөв байдал нь цаашид осол гэмтлээс урьдчилан сэргийлэх нотолгоонд суурилсан үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээллийн нэгж болдогийг онцгой анхааран эмч мэргэжилтнүүдээ зөвлөмж арга зүйгээр ханган ажиллана уу!